



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№38 /482/

2023.03.02

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ ХУРАНДАА НАРТАА 87 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ!



Монгол Улс хурандаа цол олгож эхэлсний 87 жилийн ой эл өдөр тохиож байна. Анх 2016 онд Батлан хамгаалах сайдын тушаалаар жил бүрийн 3 дугаар сарын 2-ны өдрийг "Хурандаа нарын өдөр" болгон тэмдэглэх шийдвэр гарснаас хойш 7 дахь жилдээ ийнхүү тэмдэглэн өнгөрүүлж байгаа юм.

Уг тэмдэглэлт өдрийн хүрээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудад одоо ажиллаж байгаа болон тэтгэвэр чөлөөндөө гарсан хурандаа нарын нэгдэл болох "Монгол хурандаа нийгэмлэг" ТББ-ын гишүүд нийслэлийн ОБЕГ-т чууллаа.

Хүндэтгэлийн арга хэмжээг нээж Монгол хурандаа нийгэмлэгийн ажлын албаны дарга хурандаа Л.Амарсайхан хэлсэн үгэндээ цэргийн цол нь цэргийн алба хаагчдад албан тушаалын байдал, цэргийн болон тусгай бэлтгэл, алба хаасан хугацаа, ажлын үр бүтээл, амжилтад нь тохируулан олгодог хэргэм болохыг онцлоод эл цолныхоо эзэд болсон эрхэм хурандаа нартаа Монгол хурандаа нарын өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлээ.

Үргэлжлүүлэн Монгол хурандаа нийгэмлэгийн тэргүүн, Монгол Улсын Гавьяат багш, доктор, профессор хурандаа Ч.Баатар

хэлсэн үгэндээ эх орныхоо тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад залуу халуун насаа зориулсан болон эл эрхэм үүргийг үргэлжлүүлж буй хурандаа нарынхаа энэ өдрийг амрыг эрэн мэндчилээд Монгол Улсад хурандаа цол олгож эхэлсний 87 жилийн ой, Монгол хурандаа нарын өдрийн баярын мэндийг нийт бие бүрэлдэхүүнд хүргэсэн юм.

Энэ үеэр ОБЕГ-аас онцгой байдлын албанд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Монгол хурандаа нийгэмлэгийн тэргүүн хурандаа Ч.Баатарыг ОБЕГ-ын Тэргүүний ажилтан цол тэмдгээр, хурандаа Ш.Даваасүрэн, хурандаа Л.Ганчимэг, хурандаа Б.Батмөнх нарыг Онцгой байдлын албаны төлөө нэгдүгээр зэргийн тэмдгээр тус тус шагнасан юм.

Үргэлжлүүлэн Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа М.Мөнгөнтүлгэ нийт хурандаа нартаа эл түүхэн өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлээд нийслэлийн есөн дүүргийн цэргийн штабуудад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан зарим хурандаа нарт бэлэг, дурсгалын зүйлийг гардууллаа.

Мөн энэ үеэр ОБЕГ-ын дарга хошууч генерал Г.Ариунбуянг төлөөлөн ОБЕГ-ын дэд дарга хурандаа Д.Намсрай хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Арга хэмжээний төгсгөлд өнгөрсөн 2 дугаар сард Монгол хурандаагийн өдрийг угтан зохион байгуулсан спорт болон оюуны олон төрөлт тэмцээнүүдэд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шилдгээр шалгарсан хурандаа нарт шагналыг гардууллаа.

Ташрамд дуулгахад хурандаа цолыг анх Улсын бага хурлын тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөлийн хамтарсан тогтоолоор 1936 оны 3 дугаар сарын 2-нд олгож эхэлсэн түүхтэй. Анхлан Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын цэргийн алба хаагчдад тус цолыг олгосон бол 1950 онд Цагдаагийн байгууллага, 1964 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, 1971 онд Онцгой байдлын байгууллагын алба хаагчдад тус тус олгож эхэлжээ. Өдийг хүртэл хугацаанд 3500 орчим цэргийн алба хаагч хурандаа цолыг хүртсэнээс өнөөдөр 1800 орчим нь албан үүргээ гүйцэтгэж байгаа болон тэтгэвэр чөлөөнд байна.

Ө.НАСАНТОГТОХ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	-18

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	26

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,529	3,533
EUR	3,765	3,780
CNY	511	514
RUB	46	46.70
JPY	26.20	26.50
KRW	2.71	2.74

ЗУРХАЙ



2023.03.02 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР

ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эрч хүч ихэснэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.32-18.37

Барилдлага:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДАГА:

Төрөхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.




ОЮУТАН ЦЭРГИЙН БҮРТГЭЛ тун удахгүй...

ОЮУТАН ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ТУН УДАХГҮЙ...

"Оюутан-цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэл тун удахгүй эхэлнэ.

Хамрагдах хүсэлтэй оюутнууд дараах шаардлагыг хангасан байхыг анхаарна уу!

- Нийслэл Улаанбаатар хот дахь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 1-р дамжааны оюутан байх;
- Сурлагын голч дүн 2,8-аас дээш байх;
- 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн байх;
- Эрүүл мэндийн даатгал төлөгдсөн байх зэрэг болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 680,206,721

Эдгэрсэн

Нийт: 653,025,677

Нас барсан

Нийт: 6,801,721

АХМАД НАСТНУУДАА ХҮНДЭТГЭН ЗОЛГОВ



XVII жарны “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин Туулай жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан Зэвсэгт хүчний Барилга инженерийн цэргийн Ахмадын хорооноос Барилгын цэргийн анги байгууллагуудад ажиллаж байсан ахмад

настнуудын Нэгдсэн золголтыг зохион байгуулав. Шинийн 6-ны Дашнямтай билэгт сайн өдөр болсон нэгдсэн золголтод нас сүүдэр 88 хүрч буй Л.Ганбаатар, 80 насны босго алхсан Н.Нямдэлэг, Т.Галина, Д.Рагчаа, Г.Баянням,

Д.Лхагва, С.Ичинхорлоо, Бадарч нарын олон сайхан буурлууд морилон ирж үйлс зорилго нэгтэй явсан дайчин нөхөд нь тохой өргөн хүндэтгэн золголоо.

Золголтын ажиллагааг Ахмадын хорооны гүйцэтгэх захирал, бэлтгэл хурандаа П.Наваансүрэн нээж заллага хүлээн авч хүрэлцэн ирсэн бүх хүмүүст сар шинийн мэнд дэвшүүлж, айлчлан золгож буй Туулай жилдээ энх тунх, аз жаргал дүүрэн байхын ерөөл өргөв. Нэгдсэн золголтод Монгол Улсын Гавьяат барилгачин Н.Баатархүү, БЦУГ-ын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга асан С.Батжаргал, 012, 164 дүгээр ангийн захирагч асан Ш.Буян-Өлзий, 110 дугаар ангийн захирагч асан Г.Мягмардорж, 158 дугаар ангийн захирагч асан Р.Тогтожаргал, ХЗЭ-ийн ахмад ажилтан Б.Нямбаатар, 012 дугаар ангийн Ахмадын зөвлөлийн дарга А.Хүрэлчулуун, Соёлын тэргүүний ажилтан Ш.Жавзмаа нарын 70 шахам ахмад настан хүрэлцэн иржээ.

Энэ үеэр ахмад настан Ц.Цэрэндаш Цэргийн барилгуудыг Удирдах газрын “Үйлчилгээний рот” нэртэй анх байгуулагдсан 083 дугаар ангийн түүх дурсамжийн номын дээжийг бэлтгэл хурандаа П.Наваансүрэн, цэргийн улс төр, боловсон хүчний ахмад

ажилтан, чөлөөнд байгаа дэд хурандаа Д.Рагчаа нарт өргөн барилаа. Ташрамд дурдахад, Барилгын цэргийн бүх анги түүхийн номтой болсон бөгөөд 083 дугаар ангийн түүхийн товчоон ийнхүү хамгийн отгон нь болж буй ажээ. “Л.Рагчаа гуай бидэнд ангийнхаа номыг баринтаглах үүрэг өгснийг биелүүлж байгаа юм.

Энэ номд ангийн захирагчаар ажиллаж байсан өдгөө 100 гаруй нас сүүдэр тохиож буй чөлөөнд байгаа дэд хурандаа Д.Шарав гуай гээд олон хүний дурсамж, түүх өгүүлсэн гэрэл зургууд багтсан” гэж тус ангид номын санчаар ажиллаж байсан П.Оюун онцлон хэллээ.

Барилгын цэргийн ахмад настнуудын Нэгдсэн золголтын ажиллагааг Сүхбаатар дүүргийн Иргэдийн хурлын төлөөлөгч, бэлтгэл ахмад А.Ганхуяг өөрийн амралтын газарт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, нэгэн цаг үед мөр зэрэгцэн хөдөлмөрлөж явсан нөхдөөсөө талархлын үг олонтоо сонсож байсныг дурдахгүй өнгөрч боломгүй санагдлаа. Тэрээр “Манай барилгын цэргийн ахмадууд намайг ноолоод сурчихсан хүмүүс дээ” хэмээн ярьж суусан.

Хурандаа Г.НЯМДОРЖ

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД СААТААРАЙ



Монгол Улсын Соёлын яамны шийдвэрийн дагуу төрийн болон орон нутгийн өмчийн музейн “Нээлтэй хаалганы өдөрлөг” 3 дугаар сарын 1-5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа билээ.

Энэ нь үндэсний түүх, соёл, өв уламжлал, ёс заншлаараа бахархах, хүндэтгэн дээдлэх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилготой бөгөөд Монгол Цэргийн музейн хамт олноос иргэд, олон нийтэд зориулж нээлттэй өдрүүдийг өнөөдрөөс эхлэн тав хоногийн

хугацаатай зохион байгуулж байна.

Үзвэр олон нийтэд үнэ төлбөргүй. Монгол цэргийн музейгээр үйлчлүүлэхдээ Та Монголын төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүх, үе үеийн эх орончдын байгуулсан гавьяа болон цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн олдвор, үнэлэгдэшгүй баримт, үзвэрүүдтэй танилцаж, монгол цэргийн тэмцэл, ялалтын их цадигаар “аялах” боломжтой юм.

Дэд хурандаа Л.ГАНТӨМӨР



АХМАД ДАЙЧИН МЯТАВЫН ДЭРЭМД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ойг угтаж Дорноговь аймгийн удирдлага, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийнхан Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багт оршин суугаа ахмад дайчин, өдгөө 97 насныг зооглож буй Мятавын Дэрэмд хүндэтгэл үзүүллээ.

Хүндэтгэл үзүүлэх ёслолын үеэр ахмад дайчны охин Д.Төмөртогоо

сэтгэгдлээ хуваалцахдаа “Миний аавын байгуулсан гавьяа зүтгэл, хатан зориг, туулж өнгөрүүлсэн амьдрал, амь насаа үл хайрлан тэмцсэн тусгаар тогтнолын үнэ цэнийг хойч үеийнхэн ямагт санан дурсаж бахархаж хүндэтгэл үзүүлж байдаг маш их баярлаж байна.

Дайны хүнд цаг үед “Хүн өлсөхөөс илүү цангах” хэцүү байдаг юм билээ. Ойр орчмын худгийг дайснауд хордуулж, манайхан хүн байтугай амьтан ч ойртуулахгүйгээр хамгаалалт авч, 3 сар орчим морьтой



Гэрэл зураг-нэг агшин

явахын хүнд бэрхийг үр хүүхэд ач, зээ нартаа дурсан ярьж, эх орныхоо сөөм газар урсгал усаа хамгаалахын төлөө амиа өгсөн ч гомдолгүй явсан ааваараа бахархаж байна. Аав маань идэр залуу 18 насандаа үеийн нөхөдтэйгөө дайнд мордож байсан.

Харин энэ өдөр 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнуудад оролцож байсан

алдарт 6 дугаар морьт дивизийн баатарлаг дайчдыг зоригжуулж байсан аранзал улаан Байлдааны тугаас адис авсны дараа нүднийх нь нулимс гарч байсныг хараад хамт дайтаж байсан нөхөдтэйгөө уулзсан юм шиг л сэтгэгдэл төрсөн байх даа” хэмээн талархал дэвшүүлсэн юм.

Ахмад А.АЛТАНХУЯГ



Монгол цэрэг-Дэлхийн цэрэг

